



Та манай үйлчилгээнд сэтгэл хангалуун бүс байгаа бол **ГОМДОЛ ГАРГАЖ БОЛНО.**

Та аливаа асуудлаар санал гомдол гаргаж болно, жишээ нь: танд манай ажилтан буруу зөвлөсөн, тантай зөв боловсон харьцаагүй, эсвэл хангалттай хугацаа зарцуулаагүй, ойлгомжтой яриагүй г. м

Гомдлыг та бичгээр өгч болно, эсвэл тухайн үед албан тасалгаанд буй ажилтнуудад амаар өгч болно. Мөн таны хүсэлтийн дагуу ойр дотны хүмүүс тань таны өмнөөс санал гомдлыг өгч болно.

Та бичгээр гомдол гаргасан бол:

- шуудангаар явуулж болно /хаяг: 17. listopadu 216, 530 02 Pardubice/
- нэг дүгээр давхарын шуудангийн хайрцагт эсвэл 2 дугаар давхарын хаалганы хажууд буй хайрцагт хийж болно /шуудангийн хайрцаг дээр байгуулгын нэр бий: Most pro /

Та юунд болон хэний талаар гомдол гаргаж байгаа, мөн хэзээ энэ үйл явдал тохиолдсоныг бидэнд бичээрэй. Мөн та нэрээ, хаягаа дурьдаарай. Нэр ба хаягаа та бичихийг хүсэхгүй байгаа бол нэргүй гомдол гаргаж болно.

Санал гомдлыг чех, англи, болгар, вьетнам, монгол, орос, украин, польш хэл дээр гаргаж өгч болно. Хэрэв та өөрийн орчуулагчаа авчирвал өөр хэл дээр ч гомдол гаргаж болно.

Манай ажилтан таньд, хэн гомдол саналыг барагдуулах мөн таны гомдлын тайлбарыг хэрхэн таньд дамжуулах тухай мэдээллийг олгоно. Таны гомдлын тайлбарыг 14 хоногийн дотор мэдэгдэнэ.

Нэр нь үл мэдэгдэгч гомдолын тайлбар нь дор хаяж 14 хоногийн хугацаагаар байгууллагын мэдээллийн самбар дээр байрлагдана.

Таньд гомдол гаргахад тусламж хэрэгтэй бол манай ажилтнуудаас асууна уу. Таньд баяртай туслах болно.

Гомдол гаргаснаас болоод танд бэрхшээл учрахгүй, та манай үйлчилгээг цаашдаа ашигласан хэвээр байх болно.